

2023 ОНЫ 07 ДУГААР САРЫН 05-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ




МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН 2023 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2023 ОНЫ 07 ДУГААР САРЫН 05-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

**БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААН**



ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дараах
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

2023 ОНЫ 07 ДУГААР САРЫН 05-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА
2023 оны 07 дугаар сарын 05-ны өдөр, Лхагва гараг

<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	1
<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	1-4
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	5-24
<hr/>	
1.Монгол Улсын 2022 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, “Монгол Улсын 2022 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2023.06.16-ны өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Төсвийн зарлагын хяналтын дэд хороонд хүргүүлнэ/	5-9
2.Хуулийн давхардал, хийдэл, зөрчлийг арилгах зорилгоор боловсруулсан Үндэсний их баяр наадмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай болон Хөдөлмөрийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд /Засгийн газар 2023.06.23-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/	9-10
3.“Монгол Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл	10-11
4.“Бүгд Найрамдах Улсыг тунхаглаж, анхдугаар Үндсэн хууль баталсны 100 жилийн ойг тэмдэглэх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл	11-12
5.Улсын Их Хурлын Тамгын газрын 2021-2022 оны үйл ажиллагааны тайланг сонсох	12-24

2023 ОНЫ 07 ДУГААР САРЫН 05-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

**Монгол Улсын Их Хурлын 2023 оны хаврын ээлжит чуулганы
Төрийн байгуулалтын байнгын хорооны 07 дугаар сарын 05-ны өдөр
/Лхагва гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл**

Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга Н.Энхболд ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 19 гишүүнээс 10 гишүүн хүрэлцэн ирж, 52.6 хувийн ирцтэйгээр хуралдаан 13 цаг 13 минутад Төрийн ордны “Үндсэн хууль” танхимд эхлэв.

Томилолттой: Г.Ганболд, Ц.Мөнх-Оргил, Х.Нямбаатар, Д.Сарангэрэл;

Чөлөөтэй: Ё.Баатарбилэг, Л.Оюун-Эрдэнэ;

Эмнэлгийн чөлөөтэй: Ц.Мөнхцэцэг.

Нэг. Монгол Улсын 2022 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, “Монгол Улсын 2022 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2023.06.16-ны өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Төсвийн зарлагын хяналтын дэд хороонд хүргүүлнэ/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын Шадар сайд С.Амарсайхан, Монгол Улсын Ерөнхий аудиторын орлогчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ц.Наранчимэг, Үндэсний аудитын газрын Гүйцэтгэл-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Д.Энхболд, Төрийн албаны зөвлөлийн гишүүн Д.Баатарсайхан, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Ганбат, мөн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, Татварын бодлогын газрын дарга Б.Тэлмүүн, Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын Төсвийн хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга Ж.Дэлгэржаргал нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Л.Өлзийсайхан, Улсын Их Хурлын Тамгын газрын дэд дарга Ц.Батбаатар, мөн газрын Хууль, эрх зүйн газрын дарга Н.Мягмар, Санхүү, хангамж үйлчилгээний хэлтсийн дарга Б.Лхагвасүрэн, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Д.Энхбат, мөн хэлтсийн референт Б.Галсанбат, Төрийн байгуулалтын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Хатантуул, референт Э.Баттогтох, Үйлдвэржилтийн бодлогын байнгын хороо хариуцсан референт Б.Ууганцэцэг нар байлцав.

Монгол Улсын 2022 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн талаарх аудитын дүгнэлтийг Монгол Улсын Ерөнхий аудиторын орлогчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ц.Наранчимэг, Монгол Улсын 2022 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн талаар Монгол Улсын сайд, Түгжрэлийг бууруулах үндэсний хорооны дарга Ж.Сүхбаатар нар танилцуулав.

Монгол Улсын 2022 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн талаарх аудитын дүгнэлт болон Засгийн газрын танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж Төсвийн зарлагын хяналтын дэд хорооны хуралдаанд танилцуулахаар тогтов.

2023 ОНЫ 07 ДУГААР САРЫН 05-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

Уг асуудлыг 13 цаг 28 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Хуулийн давхардал, хийдэл, зөрчлийг арилгах зорилгоор боловсруулсан Үндэсний их баяр наадмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай болон Хөдөлмөрийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд /Засгийн газар 2023.06.23-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга П.Сайнзориг, мөн яамны Хууль зүй бодлогын газрын Хувийн эрх зүйн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Н.Жамъянхүү, Монголын үндэсний бөхийн холбооны тэргүүн Ц.Магалжав, Монголын допингийн эсрэг байгууллагын гүйцэтгэх захирал Д.Мөнхболд нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Ч.Батбямба, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Д.Энхбат, референт Б.Галсанбат, мөн хэлтсийн Төрийн байгуулалтын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Хатантуул, референт Э.Баттогтох нар байлцав.

Байнгын хорооны дарга Н.Энхболд төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаар ажлын хэсгийн танилцуулгыг танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Байнгын хорооноос гарах танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн С.Амарсайхан Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 13 цаг 31 минутад хэлэлцэж дуусав.

Гурав. “Монгол Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл

Хуралдаанд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Л.Өлзийсайхан, Улсын Их Хурлын Тамгын газрын дэд дарга Ц.Батбаатар, Хууль, эрх зүйн газрын дарга Н.Мягмар, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Д.Энхбат, референт Б.Галсанбат, мөн хэлтсийн Төрийн байгуулалтын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Хатантуул, референт Э.Баттогтох, Захиргаа, хүний нөөцийн хэлтсийн референт Т.Түмэнцэцэг нар байлцав.

Байнгын хорооны дарга Н.Энхболд төслийн талаар танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Н.Энхболд: “Монгол Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг чуулганы нэгдсэн хуралдаанд оруулж батлуулах нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 5
Бүгд: 11

2023 ОНЫ 07 ДУГААР САРЫН 05-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

54.5 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболд Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 13 цаг 35 минутад хэлэлцэж дуусав.

Дөрөв. “Бүгд Найрамдах Улсыг тунхаглаж, анхдугаар Үндсэн хууль баталсны 100 жилийн ойг тэмдэглэх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл

Хуралдаанд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Л.Өлзийсайхан, Улсын Их Хурлын Тамгын газрын дэд дарга Ц.Батбаатар, Хууль, эрх зүйн газрын дарга Н.Мягмар, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Д.Энхбат, референт Б.Галсанбат, мөн хэлтсийн Төрийн байгуулалтын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Хатантуул, референт Э.Баттогтох, Захиргаа, хүний нөөцийн хэлтсийн референт Т.Түмэнцэцэг нар байлцав.

Байнгын хорооны дарга Н.Энхболд төслийн талаар танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Н.Энхболд: “Бүгд Найрамдах Улсыг тунхаглаж, анхдугаар Үндсэн хууль баталсны 100 жилийн ойг тэмдэглэх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7

Татгалзсан: 4

Бүгд: 11

63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболд Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 13 цаг 40 минутад хэлэлцэж дуусав.

Тав. Улсын Их Хурлын Тамгын газрын 2021-2022 оны үйл ажиллагааны тайланг сонсох

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Л.Өлзийсайхан, Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч М.Үнэнбат, мөн газрын дэд дарга Ц.Батбаатар, Хууль, эрх зүйн газрын дарга Н.Мягмар, Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах газрын дарга А.Энхзул, Парламентын судалгаа, сургалтын хүрээлэнгийн захирал Ц.Цогзолмаа, Гадаад харилцааны хэлтсийн дарга Ц.Жамбалдорж, Захиргаа, хүний нөөцийн хэлтсийн дарга Б.Пүрэвдагва, Санхүү, хангамж үйлчилгээний хэлтсийн дарга Б.Лхагвасүрэн, Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Д.Энхбат, мөн газрын Хуралдаан зохион байгуулах хэлтсийн дарга Н.Наранцогт, Хяналт шалгалт, үнэлгээний газрын Хяналт шалгалтын хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч С.Янжинхорлоо, Цахим парламент, инновацын газрын Мэдээллийн технологийн хэлтсийн

2023 ОНЫ 07 ДУГААР САРЫН 05-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

дарга Ж.Элбэгзаяа, Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах газрын Мэдээлэл сурталчилгааны хэлтсийн дарга Б.Батманлай нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн референт Б.Галсанбат, мөн хэлтсийн Төрийн байгуулалтын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Хатантуул, референт Э.Баттогтох, Захиргаа, хүний нөөцийн хэлтсийн референт Т.Түмэнцэцэг нар байлцав.

Улсын Их Хурлын Тамгын газрын 2021-2022 оны үйл ажиллагааны тайлангийн талаар Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Л.Өлзийсайхан танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Байнгын хорооны дарга Н.Энхболд, Улсын Их Хурлын гишүүн Ш.Адъяаа, Ж.Батсуурь, Б.Пүрэвдорж нар үг хэлэв.

Улсын Их Хурлын гишүүд Улсын Их Хурлын Тамгын газрын 2021-2022 оны үйл ажиллагааны тайланг сонсов.

Байнгын хорооны хуралдаанаар 5 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 1 цаг 16 минут үргэлжилж, 19 гишүүнээс 12 гишүүн хүрэлцэн ирж, 63.2 хувийн ирцтэйгээр 14 цаг 29 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА

Н.ЭНХБОЛД

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ ХӨТЛӨХ
АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

П.ОЮУНГЭРЭЛ

2023 ОНЫ 07 ДУГААР САРЫН 05-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2023 оны 07 дугаар сарын 05-ны өдөр,
Лхагва гараг Төрийн ордон
“Үндсэн хууль” танхим
13 цаг 13 минут.

**БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ
ТЭМДЭГЛЭЛ**

Н.Энхболд: Байнгын хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирж, ирц бүрдсэн учраас Төрийн байгуулалтын байнгын хорооны 23 оны 07 сарын 05-ны өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлуудыг танилцуулъя.

1 дүгээрт, Монгол Улсын 22 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, “Монгол Улсын, 2022 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл. Засгийн газраас өргөн мэдүүлсэн. 2 дахь хэлэлцүүлэг явуулаад санал, дүгнэлтээ Төсвийн зарлагын хяналтын дэд хороонд хүргүүлнэ.

2-т, Хуулийн давхардал, хийдэл, зөрчлийг арилгах зорилгоор Засгийн газраас боловсруулсан Үндэсний их баяр наадмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, түүнтэй хамт өргөн мэдүүлсэн Хөдөлмөрийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг хийнэ.

3 дугаарт, “Монгол Улсын Их Хурлын 23 оны намрын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл хэлэлцэнэ.

4-т, Улсын Их Хурлын Тамгын газрын 2022 оны үйл ажиллагааны тайлан сонсоно.

5-д, “Бүгд Найрамдах Улсыг тунхаглаж анхдугаар Үндсэн хууль баталсны 100 жилийн ойг тэмдэглэх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл хэлэлцэнэ.

Хэлэлцэх асуудал дээр саналтай гишүүн байна уу? Алга байна.

Хэлэлцэх асуудалдаа оръё.

Монгол Улсын 2022 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, “Монгол Улсын 2022 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн 2 дахь хэлэлцүүлгийг явуулна.

Албан тушаалтнуудыг танилцуулъя.

Шадар сайд Амарсайхан, Сангийн сайд Жавхлан, Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга Содбаатар, ҮАБЗ-ийн нарийн бичгийн дарга Энхбаяр, Ерөнхий аудитор Занданбат, ЗГХЭГ-ын тэргүүн дэд дарга Ганбат, СЕХ-ны дарга Дэлгэрнаран, Улсын Их Хурлын Тамгын газрын дэд дарга Батбаатар, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын дарга Цэнгэл, ҮАБЗ-ийн Санхүүгийн хэлтсийн дарга Отгонжаргал, Ерөнхий аудиторын орлогчийн албыг түр орлон гүйцэтгэгч Наранчимэг, Аудитын нэгдсэн удирдлага зохицуулалтын газрын захирал, тэргүүлэх аудитор Самбууням, Гүйцэтгэл-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Энхболд, ЗГХЭГ-ын Санхүү, эдийн засгийн газрын дарга Бямбасүрэн, ТАЗ-ийн гишүүн Баатарсайхан, ТАЗ-ийн Захиргаа удирдлагын газрын дарга Жавзан, СЕХ-ны ажлын албаны дарга Баяндүүрэн, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ганбат, Ганбат дарга ирсэн үү? Дуудаарай. Мөн яамны Төрийн сангийн газрын дарга Тавинжил, мөн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга Санжаадорж, мөн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө

2023 ОНЫ 07 ДУГААР САРЫН 05-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

оруулалтын газрын дарга Чимэдсүрэн, Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга Тэлмүүн, мөн яамны Төрийн сангийн газрын санхүүжилт тайлан бүртгэлийн хэлтсийн дарга Мөнхсүх, мөн яамны Хөгжлийн санхүүжилт хөрөнгө оруулалтын газрын Төсвийн хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга Дэлгэржаргал, яамны хөгжлийн санхүүжилт хөрөнгө оруулалтын газрын Хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн дарга Ганзориг, мөн яамны Төрийн сангийн газрын санхүүжилт тайлан бүртгэлийн хэлтсийн шинжээч Мөнгөнцэцэг нар ажлын хэсэгт орсон байгаа.

Нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын санхүүгийн нэгдсэн тайлангийн талаарх танилцуулгыг сайд Сүхбаатар хийнэ. Сүхбаатар гишүүнийг урьж байна.

Ж.Сүхбаатар: Сангийн сайд Засгийн газрын хуралдаан дээр бас энэ үер усны асуудал гээд мэдээлэл дээр бас байх шаардлагатай болчихоод тэгээд би уншиж танилцуулъя.

Монгол Улсын 2022 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын 22 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг хуулийн хугацаанд нэгтгэн гаргаж, Төрийн аудитын төв байгууллагаар аудит хийлгэн, Монгол Улсын Их Хурлын 2023 оны ээлжит чуулганы 07 дугаар сарын 03-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар анхны хэлэлцүүлэг танилцуулсан.

Монгол Улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийн дүн 2022 онд 17,1 их наяд төгрөг, нийт зарлага ба цэвэр зээлийн дүн 18,1 их наяд төгрөг. Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн нийт тэнцэл 1 их наяд төгрөгийн алдагдалтай гарч, төлөвлөгдсөн дүнгээс 1,8 их наяд төгрөгөөр буурсан ба сүүлийн 3 жил дараалан төсвийн алдагдлыг үе шаттайгаар буурууллаа.

Монгол Улсын нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайланд тус Байнгын хороонд харьяалагдах Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга, Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга, Ерөнхий сайд, Шадар сайд, ЗГХЭГ-ын дарга, ТА3-ийн дарга, СЕХ-ны дарга болон ҮАБЗ-ийн Ерөнхий нарийн бичгийн даргын нийт 164 байгууллагын төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг, нэгтгэн гаргасан болно.

Нэгдсэн төсвийн гүйцэтгэлээр тус Байнгын хорооны төсвийн ерөнхийлөн захирагчдын нийт зарлага болон цэвэр зээлийн дүнд 577,7 тэрбум төгрөгийн гүйцэтгэл гарч, урсгал зардалд 467,3 тэрбум төгрөг, хөрөнгийн зардалд 100,4 тэрбум төгрөгийг зарцуулсан байна. Нийт зарлага болон цэвэр зээлийн дүнгийн 33,5 хувь буюу 193,4 тэрбум төгрөгийг Шадар сайд, 41,3 хувь буюу 238,7 тэрбум төгрөгийг Ерөнхий сайд, 11,2 хувь буюу 64,5 тэрбум төгрөгийг Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга, 8,4 хувь буюу 48,5 тэрбум төгрөгийг ЗГХЭГ-ын дарга, 5,6 хувь буюу 32,5 тэрбум төгрөгийг бусад төсвийн ерөнхийлөн захирагчдын багцын зарлага эзэлж байна.

Улсын төсвөөс 563,6 тэрбум төгрөгийн санхүүжилтийг олгосон бол төсөвт байгууллагын өөрийн орлогоор 15,7 тэрбум төгрөгийн эх үүсвэрийг бүрдүүлсэн байна.

Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ, та бүхэн 2022 оны төсвийн гүйцэтгэлийн үр дүнгийн тоон үзүүлэлтүүд болон бусад холбогдох тайлан, танилцуулга, аудитын дүгнэлтүүдтэй танилцаж, Төсвийн тухай хуулийн дагуу “Монгол Улсын 2022 оны төсвийн гүйцэтгэлийг батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэж өгнө үү. Анхаарал тавьсанд баярлалаа.

Н.Энхболд: Сүхбаатар сайдад баярлалаа.

2023 ОНЫ 07 ДУГААР САРЫН 05-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

Одоо Монгол Улсын 2022 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлангийн талаарх аудитын дүгнэлтийг Ерөнхий аудиторын орлогчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Наранчимэг танилцуулна. 4 дүгээр микрофоныг өгөөрэй.

Ц.Наранчимэг: Улсын Их Хурлын Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ, Төрийн аудитын тухай хуульд заасан бүрэн эрх, төсвийн тухай хуулийн дагуу Төсвийн ерөнхийлөн захирагчдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Тус Байнгын хороонд харьяалагдах төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл болон улсын төсвийн хөрөнгө оруулалтын дүнд аудит хийсэн талаар товч танилцуулъя.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын даргын төсвийн 22 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд 5 тайлан нэгтгэгдсэнээс 2 санхүүгийн тайланд дүгнэлт гарган, 3 байгууллагыг түүвэрт хамрууллаа. Аудитаар төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд өөрчлөлтгүй дүгнэлт өгч харьяа байгууллагын санхүүгийн тайланд мөн өөрчлөлтгүй дүгнэлтийг өгсөн байна. Санхүүгийн тайлангийн аудитаар нийт 322 сая төгрөгийн зөрчил илэрсэнд 1 албан шаардлага, 4 зөвлөмжийг хүргүүлээ. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар нийт 1,5 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 0,7 тэрбум төгрөгийн санхүүжих дүнтэй 2 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээс шилжиж ирж буй 1 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 1, шинээр хэрэгжих 0,5 тэрбум төсөвт өртөгтэй 1 арга хэмжээ байна. Нийт төсөл, арга хэмжээний бодит гүйцэтгэл 100 хувьтай, санхүүжилтийн гүйцэтгэл 95,2 хувьтай байна.

Улсын Их Хурлын даргын төсвийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд 2 тайлан нэгтгэсэнээс төсвийн ерөнхийлөн захирагчид өөрчлөлтгүй дүгнэлт өглөө. Аудитаар нийт 115,6 сая төгрөгийн зөрчил илэрсэнд 2 зөвлөмжийг хүргүүлсэн байна. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар нийт 2,1 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй төсөл, арга хэмжээ хэрэгжсэн бөгөөд бодит гүйцэтгэл 100 хувьтай, санхүүжилтийн гүйцэтгэл мөн 100 хувьтай байна.

Монгол Улсын Ерөнхий сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд 41 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 37 байгууллагад дүгнэлт гаргаж 4 байгууллагыг түүвэрт хамрууллаа. Аудитаар төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн тайланд өөрчлөлтгүй дүгнэлт өгсөн бөгөөд харьяа 31 байгууллагад мөн өөрчлөлтгүй, 6 байгууллагад хязгаарлалттай санал, дүгнэлтийг өглөө. Санхүүгийн тайлангийн аудитаар нийт 26,9 тэрбум төгрөгийн 137 зөрчил илэрснээс 24,9 тэрбум төгрөгийн зөрчилд 18 төлбөрийн акт тогтоож 1,1 тэрбум төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй байх 37 албан шаардлага, 826,9 сая төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй байх 80 зөвлөмж, хариуцлага тооцох 2 албан шаардлагыг хүргүүлсэн байна. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар нийт 176,3 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 46,9 тэрбум төгрөгийн санхүүжих дүнтэй 45 төсөл, арга хэмжээ хэрэгжиж байна. Нийт төсөл, арга хэмжээний бодит гүйцэтгэл 68,9 хувьтай, санхүүжилтийн гүйцэтгэл 68,1 хувьтай байна.

Монгол Улсын Шадар сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд 97 тайлан нэгтгэсэнээс 80 байгууллагад дүгнэлт гаргаж, 17 байгууллагыг түүвэрт хамрууллаа.

Аудитаар хязгаарлалттай санал, дүгнэлт өгсөн бөгөөд 72 байгууллагад

2023 ОНЫ 07 ДУГААР САРЫН 05-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

өөрчлөлтгүй, 8 байгууллагад хязгаарлалттай санал, дүгнэлтийг өглөө. Санхүүгийн тайлангийн аудитаар нийт 27,2 тэрбум төгрөгийн 151 алдаа илэрснээс 29,1 сая төгрөгийн зөрчилд 20 төлбөрийн акт тогтоож, 21,4 тэрбум төгрөгийн алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх 56 албан шаардлага, 5,7 тэрбум төгрөгийн зөрчлийг арилгах 74 зөвлөмж, 2 албан тушаалтанд хариуцлага тооцох албан шаардлагыг хүргүүллээ. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар нийт 38,5 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 8 төсөл, арга хэмжээ хэрэгжиж байна. Нийт төсөл, арга хэмжээний бодит гүйцэтгэл 65,9, санхүүжилтийн гүйцэтгэл 99,6 хувийн хэрэгжилттэй байна.

ЗГХЭГ-ын даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд 19 санхүүгийн тайлан нэгтгэснээс 7 байгууллагад дүгнэлт гаргаж, 12 байгууллагыг аудитаар түүвэрт хамрууллаа. Санхүүгийн нэгтгэсэн тайланд өөрчлөлтгүй дүгнэлт өгсөн бөгөөд харьяа 7 байгууллага бүгд өөрчлөлтгүй дүгнэлтийг авсан байна. Санхүүгийн тайлангийн аудитаар нийт 67,2 сая төгрөгийн 21 зөрчил илэрснээс 89,2 сая төгрөгийн 7 алдааг залруулж, 1 албан шаардлага, 14 зөвлөмжийг өгсөн байна. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар нийт 76,3 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 31 төсөл, арга хэмжээ хэрэгжиж байгаа бөгөөд нийт төсөл арга хэмжээний бодит гүйцэтгэл 51,3 хувьтай, санхүүжилтийн гүйцэтгэл 95,7 хувьтай байна.

СЕХ-ны даргын 2022 оны санхүүгийн тайланд өөрчлөлтгүй санал, дүгнэлт өгсөн бөгөөд аудитаар нийт 8,4 сая төгрөгийн 3 зөрчил илэрсний 0,5 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоож 7,9 сая төгрөгийн зөрчлийг арилгах 2 албан шаардлагыг хүргүүллээ.

ТАЗ-ийн даргын 2022 оны санхүүгийн тайланд өөрчлөлтгүй санал,

дүгнэлт өгсөн бөгөөд санхүүгийн тайлангийн аудитаар 18,6 сая төгрөгийн зөрчил илэрч 3 зөвлөмжийг өгсөн байна.

ҮАБЗ-ийн нарийн бичгийн даргын 2022 оны санхүүгийн тайланд өөрчлөлтгүй санал, дүгнэлтийг өгсөн бөгөөд аудитаар нийт 76 сая төгрөгийн 3 зөрчил илэрснийг 1 албан шаардлага 2 зөвлөмжийг хүргүүлсэн байна.

Тус Байнгын хороонд харьяалагдах төсвийн ерөнхийлөн захирагчдын санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар цаашид анхаарах дараах асуудлыг толилуулж байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн хэрэгжүүлсэн хөтөлбөр, хөтөлбөрийн үр дүн, чанар, тоон хэмжээг төсвийн гүйцэтгэлд уялдуулан хяналт шинжилгээ, үнэлгээ хийж баталгаажуулахгүй байна. Монгол Улсын Засгийн газрын 2020-24 оны үйл ажиллагааны хөтөлбөр, 2021-2025 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин тодорхойгүйгээс улс орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний үр дүнг бодитой үнэлэх боломжгүй байна.

Төсөл, арга хэмжээний гүйцэтгэл, хэрэгжилтэд тавьж буй захиалагчийн болон зохиогчийн хяналт үр дүнгүй, төсвийн ерөнхийлөн захирагчдын дотоод аудитын нэгж нь хөрөнгө оруулалтын үйл ажиллагаанд хяналт хийхгүй байгаа нь зөрчил арилахгүй байх гол шалтгаан болж байна.

Төсөвлөлтийн шаардлага хангахгүй төсөл, арга хэмжээг санхүүжүүлж байгаа нь хөрөнгө оруулалтын үр өгөөж буурах, төсөвт ачаалал үүсгэж буй талаар жил бүр аудитаар өгсөн дүгнэлт, зөвлөмжийг хэрэгжүүлэхгүй байгаа нь Төсвийн тухай хуульд заасан төсөвлөлтийн шаардлагыг хангахгүй зөрчсөн хэвээр байна.

2023 ОНЫ 07 ДУГААР САРЫН 05-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

Аудитын дүн, дүгнэлтийг тоймлон танилцууллаа. Анхаарал хандуулсанд баярлалаа.

Н.Энхболд: Баярлалаа. Нэгдсэн төсвийн гүйцэтгэл, энэ талаарх тайлангийн талаар аудитын дүгнэлттэй холбогдуулаад асуух гишүүн байна уу? Байхгүй байна.

Үг хэлэх гишүүн байна уу? Байхгүй байна.

Үүгээр Монгол Улсын 2022 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлангийн 2 дахь хэлэлцүүлгийг явуулж дууслаа.

Байнгын хорооны санал, дүгнэлтийг Төсвийн зарлагын хяналтын дэд хороонд Улсын Их Хурлын гишүүн Пүрэвдорж танилцуулна. Ажлын хэсгийн гишүүдэд баярлалаа.

13.28 цаг

Дараагийн асуудалдаа оръё.

Засгийн газраас өргөн мэдүүлсэн Хуулийн давхардал, хийдэл, зөрчлийг арилгах зорилгоор боловсруулсан Үндэсний их баяр наадмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль, мөн түүнтэй хамт өргөн мэдүүлсэн Хөдөлмөрийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг явуулна.

Би эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн танилцуулгыг та бүхэнд тараасан байгаа. Унишж танилцуулъя.

Монгол Улсын Засгийн газар 2023 оны 06 сарын 23-ны дотор Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Хуулийн давхардал, хийдэл, зөрчлийг арилгах зорилгоор боловсруулсан Үндэсний их баярын баярын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай болон Хөдөлмөрийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийн анхны

хэлэлцүүлгийг Улсын Их Хурлын 2023 оны 07 сарын 03-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж, эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр ТББХ-нд шилжүүлсэн.

ТББХ 2023 оны 07 сарын 05-ны өдрийн хуралдаанаараа Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлд заасан журмын дагуу Үндэсний их баяр наадмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай болон Хөдөлмөрийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг явууллаа.

Байнгын хорооны хуралдааны хуулийн төслүүдийн эцсийн хэлэлцүүлэг явахад Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр олонхын дэмжлэг авсан саналуудыг хуулийн төсөлд нэмж тусган эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн төслүүд, Байнгын хорооны танилцуулгыг та бүхэнд хүргүүлсэн байгаа.

Ажлын хэсгийг танилцуулъя. ХЗДХЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга Сайнзориг, ХЗДХЯ-ны Хууль зүйн бодлогын газрын Хувийн эрх зүйн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Жамъянхүү, Үндэсний бөхийн холбооны тэргүүн Магалжав, Монголын допингийн эсрэг холбоо байгууллагын гүйцэтгэх захирал Мөнхболд нар оролцож байгаа.

Эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн танилцуулгатай холбогдуулж асуух гишүүн байна уу? Байхгүй байна.

Санал хэлэх гишүүн байна уу? Алга байна.

Хуулийн давхардал, хийдэл, зөрчлийг арилгах зорилгоор боловсруулсан Үндэсний их баяр наадмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай болон Хөдөлмөрийн тухай хуульд өөрчлөлт

2023 ОНЫ 07 ДУГААР САРЫН 05-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

оруулах тухай хууль энэ төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг явуулж дууслаа.

Танилцуулгыг Тоогий дарга хийчих үү. Амарсайхан сайд чуулган дээр баяр наадмынхаа хуулийн Байнгын хорооны танилцуулгыг хийнэ шүү.

13.31 цаг

Дараагийн асуудалдаа орёё.

“Монгол Улсын Их Хурлын 23-ны ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэнэ.

Би танилцуулаадахъя. Бэлтгэсэн танилцуулгыг би та бүхэнд уншаад танилцуулъя.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1 дэх хэсэгт ТББХ нам, эвслийн бүлэг, Байнгын, дэд, түр хороо хууль санаачлагчийн саналыг үндэслэн дараагийн чуулганаар хэлэлцэх асуудлын талаарх Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төслийг боловсруулан нэгдсэн хуралдаанд оруулж, хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар батална гэж заасны дагуу ТББХ “Монгол Улсын Их Хурлын 23 оны намрын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсрууллаа.

Чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3 дахь хэсэгт заасны дагуу Улсын Их Хурлын 23 оны намрын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудалтай холбогдуулан Засгийн газраас 106, Улсын Их Хурал дахь Монгол Ардын намын бүлгээс 27, Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгээс 27, Байнгын хороодоос 51, Улсын Их Хурлын гишүүнээс 2 хууль, тогтоолын санал ирүүлсэн байгаа.

23 оны намрын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын тухай тогтоолын

төслийг боловсруулахдаа дараах зарчмуудыг боловсруулсан. Үүнд:

1 дүгээрт баримталсан байгаа.

1 дүгээрт Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтүүд, хууль тогтоомжийг нийцүүлэх, түүнтэй холбогдуулан авах арга хэмжээний тухай Улсын Их Хурлын 20 оны 2 дугаар тогтоол, Монгол Улсын хууль тогтоомжийг 24 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл батлах тухай Их Хурлын 21 оны 12 дугаар тогтоолд 23 онд Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр тусгасан хууль, тогтоолын төслүүд, шинэ сэргэлтийн бодлого батлах тухай Улсын Их Хурлын 21 оны 106 дугаар тогтоолоор баталсан 5 дугаар хавсралтад туссан хууль, тогтоолын төслүүд, “Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлттэй холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын 23 оны 44 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтад туссан хууль, тогтоолын төслүүдийг тухай бүр нь хэлэлцүүлэх зарчмыг баримтлан тусгасан.

Мөн хэлэлцүүлгийн шатанд байгаа болон хууль санаачлах эрх бүхий субъектүүдээс өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслийг Улсын Их Хурлын даргын дэргэдэх зөвлөлийн саналыг харгалзан хэлэлцэх асуудлуудын дараалалд оруулах асуудлыг Улсын Их Хурлын дарга шийдвэрлэхээр тусгасан байгаа.

Ингээд нийтдээ намрын чуулганаар 62 хууль, тогтоолыг хэлэлцэхээр саяын дараалал зарчмуудыг баримтлаад төсөлд тусгасан байгаа.

Тогтоолын төсөл, танилцуулгатай холбогдуулаад асуулт асуух гишүүн байна уу? Байхгүй байна.

Үг хэлэх, санал гэж хэлэх гишүүн байна уу? Алга байна.

Тэгвэл санал хураалт явуулна.

2023 ОНЫ 07 ДУГААР САРЫН 05-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

“Монгол Улсын Их Хурлын 23 оны намрын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг чуулганы нэгдсэн хуралдаанд оруулж батлуулах нь зүйтэй гэсэн томъёоллоор санал хураалт явуулна.

Гишүүд байраа эзэлье. Бямбацогт гишүүн ээ, байрандаа суугаарай. Пүүжээ гишүүн ээ санал хураах гэж байна шүү. Санал хураалт.

Хуралдаанд оролцсон гишүүдийн 54,5 хувиар санал дэмжигдлээ.

Байнгын хорооны санал, дүгнэлтийг би танилцуулчихъя.

“Монгол Улсын Их Хурлын 23 оны намрын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэж дууслаа.

13.35 цаг

Дараагийн асуудалд оръё.

“Бүгд Найрамдах Улсыг тунхаглаж, анхдугаар Үндсэн хууль баталсны 100 жилийн ойг тэмдэглэх тухай” Улсын Их Хурлын тогтоолыг хэлэлцэнэ.

100 жилээ, Үндсэн хуулийн. Би танилцуулга хийе.

Улсын анхдугаар Их Хурал 1924 оны 09 сарын 08-ны өдөр Нийслэл хүрээнд эхэлж, Их Хурлаар олон асуудал хэлэлцэж шийдэгдсэний дотор Олноо өргөгдсөний 14 дүгээр он буюу 24 оны 11 сарын 26-ны өдөр бүх Монгол Улсыг үүнээс хойш Бүгд Найрамдах Бүрэн эрхтэй Ард Улс хэмээн дотоод ба гадаадад тунхаглан зарлаж, хуульчлан баталгаажуулсныг 20 дугаар зууны Монгол Улсын түүхэн дэх онцгой үйл явдал гэж үздэг.

Анхдугаар Үндсэн хууль баталж, Бүгд Найрамдах улс тунхагласны 70

жилийн ой болон Монгол Улсын Үндсэн хуулийн 5, 10 жилийн ойг Улсын Их Хурлын тогтоолоор, 25 жилийн ойг Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар, мөн 30 жилийн ойг Монгол Улсын Их Хурлын тогтоолоор тус тус тэмдэглэн хүүрүүлсэн байна.

Монгол Улсын Их Хурлаас 2003 онд баталсан Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.9 дэх заалтад Бүгд Найрамдах Улс тунхагласан 11 дүгээр сарын 26-ны өдрийг жил бүр нийтээр тэмдэглэх баярын өдөр болгон тэмдэглэхээр заасан. Мөн Төрийн ёслол журам батлах тухай Ерөнхийлөгчийн 2015 оны 119 дүгээр зарлигаар тэгш ой тохиосон жил Үндсэн хуулийн өдрийг тусгай хөтөлбөрөөр тэмдэглэхээр заасан байгаа. Анхдугаар Үндсэн хуулийн Монгол Улсын түүх, нийгэмд гүйцэтгэсэн үүрэг, түүхэн ач холбогдлыг тэмдэглэж, Үндсэн хуулиа дээдлэн сахих үзлийг түгээн дэлгэрүүлэн зүйтэй хэмээн үзэж, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэг, Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуулийн 4 дүгээр зүйр нь зүйлийн 4.1.9 дэх заалт, 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсгийг тус тус үндэслэн Бүгд Найрамдах Улсыг тунхаглаж, анхдугаар Үндсэн хууль баталсны 100 жилийн ойг тэмдэглэх тухай Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсрууллаа.

Тогтоолын төсөл 6 заалттай. Анхдугаар Үндсэн хууль баталсны 100 жилийн ой 2020 онд тохиож байгаатай холбогдуулан Монгол Улсын Үндсэн хуулийг иргэн бүр эрхэмлэн дээдлэх үзэл санааг олон нийтэд түгээн тайлбарлах, таниулах, иргэдэд сурталчлах ажлыг улс орон даяар зохион байгуулах, дээрх ажлыг зохион байгуулахад мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэхийг Монгол Улсын Их Хурлын Тамгын газарт, түүхэн ойд бэлтгэх, тэмдэглэн өнгөрүүлэх талаар төлөвлөгөө боловсруулж, холбогдох арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Засгийн

2023 ОНЫ 07 ДУГААР САРЫН 05-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

газарт даалгах зохицуулалтуудыг энэ тогтоолын төсөлд тусгасан байгаа.

Тогтоолын төсөл батлагдсанаар нийгэм, эдийн засаг, хууль зүйн аливаа сөрөг үр дагавар үүсэхгүй, Бүгд Найрамдах Улс тунхагласан өдрийн хүрээнд Монгол Улсын Үндсэн хуулийн үзэл санааг түгээн дэлгэрүүлэх, сурталчлах ажлыг зохион байгуулах, анхдугаар Үндсэн хууль батлагдсаны 100 жилийн ойг улс орон даяар тэмдэглэн өнгөрүүлэх эрх зүйн үндэс бүрдэнэ. Ийм танилцуулга хийе.

Тогтоолын төслийг та бүхэнд танилцуулсан байгаа. Тараасан байгаа. Тогтоолын төсөлтэй холбогдуулаад асуулт асуух гишүүн байна уу? Алга байна.

Үг хэлэх гишүүн байна уу? Байхгүй байна.

“Бүгд Найрамдах Улсыг тунхаглаж, анхдугаар Үндсэн хууль баталсны 100 жилийн ойг тэмдэглэх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг дэмжих нь зүйтэй гэсэн томъёоллоор санал хураалт явуулья.

Санал хураалт, гишүүд ээ.

Хуралдаанд оролцсон гишүүдийн 63,6 хувь нь саналыг дэмжлээ.

Ингэснээр “Бүгд Найрамдах Улсыг тунхаглаж, анхдугаар Үндсэн хууль баталсны 100 жилийн ойг тэмдэглэх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэж дууслаа.

Чуулганы нэгдсэн хуралдаанд би өөрөө танилцуулчихъя.

13.40 цаг

Дараагийн асуудалдаа оръё.

Улсын Их Хурлын Тамгын газрын 21 оны үйл ажиллагааны тайланг

сонсоно. 22 оны ажлын тайланг сонсоно.

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.2-т Тамгын газрын үйл ажиллагааны тайланг Ерөнхий нарийн бичгийн дарга ТББХ-нд жил бүр танилцуулах бөгөөд шаардлагатай гэж үзвэл уг Байнгын хороо дүнг нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлж болно гэж заасан байгаа.

Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулаад оролцож байгаа ажлын хэсэг, албан тушаалтнуудыг танилцуулъя.

Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Өлзийсайхан, Улсын Их Хурлын Тамгын газрын тэргүүн дэд даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Үнэнбат, байна уу, Тамгын газрын дэд дарга Батбаатар, Хууль зүйн эрх зүйн газрын дарга Мягмар, Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах газрын дарга Энхзул, Парламентын судалгаа, сургалтын хүрээлэнгийн захирал Цогзолмаа, Гадаад харилцааны хэлтсийн дарга Жамбалдорж, Захиргаа, хүний нөөцийн хэлтсийн дарга Пүрэвдагва, Санхүү, хангамж үйлчилгээний хэлтсийн дарга Лхагвасүрэн, наашаа сууцгаачхаарай. Цахим парламент, инновацын газрын Мэдээллийн технологийн хэлтсийн дарга Элбэгзаяа, Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Энхбат, Хууль, эрх зүйн газрын Хуралдаан зохион байгуулах хэлтсийн дарга Наранцогт, Хяналт шалгалт, үнэлгээний газрын Хяналт шалгалтын хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Янжинхорлоо, Хяналт шалгалт үнэлгээний газрын Төсвийн хяналт шинжилгээний хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Эрдэнэсамбуу, Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах газрын Мэдээлэл сурталчилгааны хэлтсийн дарга Батманлай. Эдгээр хүмүүс оролцож байна.

2023 ОНЫ 07 ДУГААР САРЫН 05-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

Одоо тайланг Ерөнхий нарийн бичгийн дарга Өлзийсайхан танилцуулна. 3 дугаар микрофоныг өгье.

Ажлын хэсгийн 3 дугаар микрофон асаагүй байна уу? 3 дугаар микрофон. Асаагүй байна уу. 3 дугаар микрофон. Яагаад байна. 2 дээр очих юм уу? 2 дугаар микрофон өгөөдөх дөө. Аль нь асав? 2 дугаар микрофон ажлын хэсгийн. Ажлын хэсгийн 2 дугаар микрофон. Техникийн алба сонсож байна уу, үүнийг. Түрүүн энэ 4 дүгээр микрофон ажиллаж байсан даа, тэгвэл ядаж тэр 4-ийг өгөөч, та нар. 4 ажиллалаа, 4 дээр очоорой, Өлзийсайхан дарга аа. 4 номерын микрофон энэ ажиллахгүй байна.

Л.Өлзийсайхан: Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ, Та бүхний энэ өдрийн амгаланг айлтгая.

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.2 дахь хэсэгт заасны дагуу Улсын Их Хурлын Тамгын газрын 2021, 2022 оны үйл ажиллагааны тайланг Төрийн байгуулалтын байнгын хороонд танилцуулж байна.

2021, 2022 он бол Улсын Их Хурлын Тамгын газраас парламентын мэргэшсэн, хариуцлагатай, бүтээлч, ёс зүйтэй ажлын албыг төлөвшүүлэх эрхэм зорилгоо хэрэгжүүлэхэд чиглэсэн томоохон шинэ ажлуудыг эхлүүлсэн шинэчлэлийн он жилүүд болж түүхэнд үлдэж байна.

Манай Улсын Их Хурлын Тамгын газраас 2021-2024 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны стратеги төлөвлөгөөгөө баталсан бөгөөд 2021 онд 51 зорилт 329 арга хэмжээ, 2022 онд 45 зорилт 306 арга хэмжээг тус тус төлөвлөж хянан шалгалт үнэлгээ шинжилгээний дүнгээр 92,2 хувийн биелэлттэй байна. Түүнчлэн Монгол Улсын Их Хурлын ТББХ-ноос 6 чиглэлээр өгсөн үүрэг даалгаврыг бүрэн хэрэгжүүлж ажиллав. Бид энэхүү тайлант хугацаанд хууль тогтоох, хянан

шалгах үйл ажиллагааны бүтээмж, үр нөлөөг сайжруулах, мөн хүний эрх, жендерийн мэдрэмжтэй хууль тогтоох үйл ажиллагааг төлөвшүүлэх, нээлттэй, ил тод, парламентыг төгөлдөржүүлэх, цахим парламентыг идэвхжүүлэхэд эрчимжүүлэхэд онцгойлон анхаарч ажилласан билээ.

Мөн хүүхэд, залуус, иргэдэд парламентын боловсролыг түгээн дэлгэрүүлэх, хууль тогтоох үйл ажиллагаанд шинжлэх ухаанч мэдлэг мэдээллээр хангах, парламентын гадаад харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлэх, үр нөлөөг дээшлүүлэх, захиргаа санхүүгийн үйл ажиллагааг эрсдэлийн бодлого суурьд үндэслэсэн ажлуудыг нэн тэргүүний зорилт болгон дэвшүүлсэн юм. Эдгээр зорилтуудын хүрээнд зохион байгуулсан үйл ажиллагаа, хүрсэн үр дүнг та бүгдэд танилцуулъя.

1 дүгээрт, Улсын Их Хурлын хууль тогтоох үйл ажиллагааны чиглэлээр

Тамгын газраас 2021 онд 515 хууль, 106 тогтоолын төслийг, мөн 2022 онд 584 Улсын Их Хурлын Тогтоолыг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэж батлуулсан бөгөөд 21 оныг өмнөх онтой харьцуулахад 72,2 хувиар, 2022 оныг 2021 онтой харьцуулахад 23 хувиар тус бүр өссөн байна.

Мөн нэгдсэн хуралдааны болон Байнгын, дэд, түр хуралдааныг 2021 онд 338 удаа, 2022 онд 364 удаа танхимаар болон цахимаар зохион байгуулсан байгаа. 2021 он бол цар тахлын хязгаарлалтын үе байсан учраас нийт нэгдсэн хуралдааны 50,6 хувь буюу 42 хуралдааныг цахимаар хуралдуулсан бол 2022 онд цар тахлын хязгаарлалт цуцлагдсантай холбоотойгоор нийт хуралдааны 3 хуралдааныг цахимаар хуралдуулсан.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд туссан цахим хуралдааны дэгийг өнгөрсөн 2 жил хугацаанд Улсын Их Хурлын Тамгын

2023 ОНЫ 07 ДУГААР САРЫН 05-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

газраас бүрэн хэрэгжүүлж, арга зүй, зохион байгуулалтын хувьд бүрэн туршилагатай болж, цаашид Улсын Их Хурлын үйл ажиллагааг хэвийн, найдвартай, тасралтгүй явуулахад бэлтгэл ажлыг бид хангасан байна. Эндээс дүгнэж үзвэл парламентын хууль тогтоох үйл ажиллагаанд мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлж техник зохион байгуулалтаар хангах, Улсын Их Хурлын үйл ажиллагаа тасралтгүй мөн хэвийн явагдах боломж нөхцөлийг хангах чиг үүргээ үр дүнтэй бүтээмжтэй хэрэгжүүлж чадсан гэж бид үзэж байна.

Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд хууль тогтоомжийг нийцүүлэх түүнтэй холбогдуулан авах арга хэмжээний тухай 2020 оны 02 дугаар тогтоолд нийт 31 хуульд өөрчлөлт оруулахаар тогтоосон байгаа. Уг 2022 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар нийт 31 хууль батлахаас 18 хуулийг баталсан байгаа нь тогтоолын хэрэгжилт 58 хувьтай байна. Уг 18 хуулийг боловсруулан батлуулахад Улсын Их Хурлын Тамгын газраас мэргэжил, арга зүй, техник, зохион байгуулалтын туслалцааг үзүүлж ажиллалаа.

Улсын Их Хурлын Тамгын газраас мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх хүрээнд Улсын Их Хурлын гишүүдийн боловсруулсан санаачилсан 83 хууль тогтоомжийн төсөл, түүний үзэл баримтлал, танилцуулгыг боловсруулахад туслалцаа үзүүлж ажилласан бөгөөд ҮХЦ-д албан ёсны тайлбарыг итгэмжлэгдсэн төлөөлөгчийн тайлбарын 25 төслийг бэлтгэж хүргүүлсэн байна.

Мөн Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн хууль тогтоомжийг Монгол Улсын Үндсэн хууль бусад хууль, олон улсын гэрээнд нийцэж байгаа эсэх талаар тайлант хугацаанд 7 удаа дүгнэлт гаргасан 227 хууль тогтоомжийн бүрдүүлбэрийг хянасан бөгөөд 1107 ширхэг хууль, тогтоолын төслийн эцсийн найруулгыг хянаж албажуулсан байна.

Нийт 707 хууль 179 тогтоолыг бид нэгдсэн болон дотоод албан ёсны, цахим системд байршуулж, эхийг тулгаж, хянаж ажилласан. Энэ бүгдээс дүгнэж үзвэл Тамгын газар Монгол Улсын Их Хурал хууль тогтоох үндсэн чиг үүрэг, бүрэн эрхээ бүтээмжтэй, үр нөлөөтэй хэрэгжүүлэхэд Үндсэн хууль, холбогдох бусад хууль тогтоомжийн нийцлийг хангасан мэргэжлийн өндөр түвшний зөвлөгөө, туслалцааг хүртээмжтэй, шуурхай хүргэсэн байна.

Монгол Улсын Их Хурал Олон улсын парламентын холбоотой санамж бичиг байгуулсан. Мөн бусад улс орнуудын парламент түүний Тамгын газрын сайн туршилага, жишигийг судалж, НҮБ-ын хүний эрхийн дээд комиссараас гаргасан хүний эрхийн суурь үзүүлэлтийг хангах гарын авлага болоод жишигийг үндэслэн хүний эрхэд нөлөөлөх байдлын үнэлгээ хийх аргачлалыг Тамгын газар дотроо боловсруулж, өнөөдрийг хүртэл хэрэгжүүлж байна.

Мөн бид хуралдааны тэмдэглэлийн шинэ загвар бүтцийг боловсруулж ажиллаж байгаа. Ингэхдээ бид нар Их Британи, Герман, Канад, Шотландын парламентын сайн туршилагыг судалж энэ үндсэн дээрээ Улсын Их Хурлын чуулганы хуралдааны тэмдэглэлийн загвар бүтцийг шинэчлэн боловсруулсан байгаа. Шинэ загвар бүтцийнхээ хүрээнд 2021 онд нэгдсэн болон Байнгын, дэд, түр хорооны хуралдааны 12237 хуудас, 2022 онд 14687 хуудсыг албажуулж, баталгаажуулсан байна. Энэхүү ингэж ажилласнаар олон улсын парламентуудын шилдэг жишигт нийцсэн аргачлал загварыг баталж хэрэгжүүлснээр хүний эрхийн мэдрэмжтэй хууль тогтоох мөн парламентын нээлттэй ил тод байдлыг хангахад тодорхой хэмжээнд бид боломжийг стратеги төлөвлөгөөнд тусгасан боломжоо хэрэгжүүлэн ажиллалаа.

2023 ОНЫ 07 ДУГААР САРЫН 05-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

2 дугаарт, Улсын Их Хурлын хянан шалгах үйл ажиллагааны чиглэлээр

Монгол Улсын Их Хурлын хянан шалгалтын тухай хууль 2021 онд батлагдсан байгаа. 2022 оноос Улсын Их Хурлын хянан шалгах бүрэн эрхээ шинэ хууль, эрх зүйн орчинд хэрэгжүүлж эхэлсэн шинэ онцлог жил байлаа. 2021 онд 37 ажлын хэсэг давхардсан тоогоор 256 гишүүн, мөн 2022 онд 40 ажлын хэсэг давхардсан тоогоор 313 гишүүн Хянан шалгах түр хороо, ажлын хэсэгт ажилласан байна. Өмнөх онтой харьцуулаад үзэхэд ажлын хэсгийн тоо 7,5 хувь, мөн ажлын хэсэгт оролцсон гишүүдийн тоо 18,2 хувь өссөн байна.

Тайлант хугацаанд хяналтын сонсгол 9 удаа явуулсан байгаа. Үүнээс 1 дүгээрт Ерөнхий хяналтын сонсгол 1 удаа, хүний эрх эрх чөлөөг хангахтай холбоотой хяналтын сонсгол 1 удаа, мөн нэр дэвшигчийн сонсгол 6 удаа явуулсан байна.

Нээлттэй хэлэлцүүлэг 4 удаа, 33 ажлын хэсэг, 4 түр хороо байгуулагдан ажилласан бөгөөд уг үйл ажиллагаанд хяналт шалгалтыг хэрэгжүүлэх чиг үүргийн хүрээнд Улсын Их Хурлын Тамгын газраас мэргэжил, арга зүй, техник туслалцааны зохих зөвлөгөөг үзүүлж ажиллалаа.

Мөн Улсын Их Хурлын гишүүд 25 төрийн байгууллагад, 15 аймагт очиж ажилласан байна. Энэ хүрээнд 2 Улсын Их Хурлын тогтоол мөн Байнгын хорооны тогтоол 9-ийг, түр хороо ны тогтоол 4, түр хорооны 4 тэмдэглэлээр өгсөн үүрэг даалгаврыг Засгийн газар болон холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлэхэд мэргэжлийн зүгээс оролцож ажилласан. Үүнээс гадна хянан шалгах 3 түр хороо буюу эмийн, нүүрсний, мөн Хөгжлийн банкны асуудлаарх энэ түр хорооны үйл ажиллагаанд Тамгын газраас мэргэжил, арга зүй, техник, зохион байгуулалтын туслалцаа үзүүлж, гэрчийг дуудах, мөн шинжээчийг томилон

ажиллуулах зэрэг үйл ажиллагаанд жишигийг тогтоож, процедурын үйл ажиллагаанд оролцож ажилласан. Ингэснээр Монгол Улсад парламентын хяналт шалгалтын цоо шинэ тогтолцоо бүрдэж, Улсын Их Хурлын хянан шалгах чиг үүргийн хүрээ далайц нэмэгдсэнийг харуулж байна.

Улсын Их Хурлын гишүүдээс Монгол Улсын Ерөнхий сайд мөн Засгийн газрын гишүүд холбогдох байгууллагын албан тушаалтнуудад давхардсан тоогоор 105 гишүүнээс 62 асуулгыг 336 асуудлаар, мөн 41 гишүүнээс 39 асуултыг 136 асуудлаар явуулсны хүрээнд энэ хүрээнд Улсын Их Хурлын Тамгын газар мөн мэргэжил, арга зүй, техник, зохион байгуулалтын туслалцааг үзүүлж ажилласан байна.

Ерөнхий сайдын мэдээлэл тайлант хугацаанд 23 удаа хийгдсэн байгаа. 2022 онд үүнээс 6 удаагийн Ерөнхий сайдын мэдээлэл дээр ди цахим парламент системд байршуулж, иргэдээс саналыг авч уг асуултыг нэгдсэн хуралдаан дээр Ерөнхий сайд болон холбогдох албан тушаалтнуудаас асуулт асууж, хариулт авсан.

Хууль тогтоомжийн хэрэгжилтийг үнэлэх үйл ажиллагааны хүрээнд хянах үйл ажиллагааны хүрээнд 2021 онд 9 удаа, 2022 онд 7 удаа хяналт шинжилгээ үнэлгээг хэрэгжүүлж ажиллалаа. Мөн тайлан, илтгэл, мэдээлэл сонсох хүрээнд 2021 онд 47 удаа, 2022 онд 38 удаа, давхардсан тоогоор 636 гишүүн мөн 1787 асуултаас асууж, хариултыг бэлтгэж ажилласан. Энэхүү хүрээнд Тамгын газар хяналт шинжилгээнд үнэлгээний цоо шинэ мөн байнгын тогтолцоо чадавх бүрдсэн нь тайлант хугацааны хувьд хамгийн чухал бас нэг үр дүнтэй үйл ажиллагаа болсон юм.

3 дугаарт, Улсын Их Хурлын үйл ажиллагааг цахим шилжилтэд шилжүүлэх чиглэлээр хийсэн ажлыг хураангуйлан танилцуулъя.

2023 ОНЫ 07 ДУГААР САРЫН 05-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

Цахим парламент, инновац хариуцсан бүтцийн нэгжийг 2022 онд Тамгын газарт байгуулан ажиллаж байна. Мөн веб аппликэйшн хосолсон ди парламент цахим системийг 2022 онд хэрэглээнд нэвтрүүлээ. Уг тайлант хугацаанд ди парламент цахим системд нийт 5200 иргэн оролцон хандсан бол 210 удаагийн хандалт явагдсан байна. Өнгөрсөн онд цахим системийг байршуулсан Монгол Улсын 2023 оны төсвийн төсөл мөн төсвийн хүрээний мэдэгдэлтэй 10500 иргэн танилцсан байна. Энэхүү иргэдийн саналыг тусгасан улсын төсвөө ард олонтойгоо бас хамтран хэрэгжүүлэх ажлыг анх удаа ингэж хийсэн ажил болж түүхэнд үлдэж байна.

Улсын Их Хурлын чуулганы хуралдааны цахим системийг бид үе шаттайгаар хэрэгжүүлэхээр мөн төлөвлөсөн байгаа. Эхний үе шат маань явагдаж байна. Мөн 2023 онд 2 дугаар үе шатныхаа ажлыг бид нар төлөвлөн хэрэгжүүлээд явж байна.

Улсын Их Хурлын цахим хуудсыг бид Англи болоод мөн тодорхой түвшинд мобайл, хувилбарт шилжүүлсэн байгаа. Энэ хүрээндээ сайжруулах ажлуудыг мөн бид хийж байна. Эндээс дүгнэж үзвэл Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн хуулийн төсөлд иргэд, сонгогчдын саналыг авах мөн цахим хэлэлцүүлэг өрнүүлэх, иргэд асуулт асуух мөн гомдол санал хүсэлтээ илгээх албан ёсны цахим тайлбартай болсон нь Улсын Их Хурал Тамгын газрын үйл ажиллагаанд цахим шилжилт хийх стратеги зорилтоо хэрэгжүүлэхэд томоохон алхам болсон гэж дүгнэн үзэж байна.

4 дүгээрт, Улсын Их Хурлын төлөөллийн чиг үүрэг мөн үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг хангах чиглэлээр хийсэн ажлыг танилцуулъя.

Энэ хүрээнд Байнгын хороодоос чиглэл үүрэг өгсний дагуу нийтийн

сонсгол 11 удаа, мөн 124 хэлэлцүүлэг, сургалт семинар 59 удаа, уулзалт ярилцлагыг 354 удаа зохион байгуулсан байна. Уг ажилд Улсын Их Хурлын Тамгын газар мөн мэргэжил, арга зүй, техни, зохион байгуулалтын туслалцааг үзүүлсэн.

Түүнчлэн хууль тогтоомжийн төсөл боловсруулах, хэлэлцэн батлах үе шат, Улсын Их Хурлаас томилогддог албан тушаалтны томилгоонд олон нийтийн оролцоог хангах үйл ажиллагаанд техник, зохион байгуулалтын дэмжлэг туслалцааг үзүүлж ажилласан.

Бид өнөөдөр парламентын боловсрол мөн өсвөрийн парламент гэсэн хөтөлбөрүүдийг 2 дахь жилдээ амжилттай хэрэгжүүлээд явж байна. Энэ хүрээнд нийслэлийн хамгийн залуу багш, түүх, нийгмийн хичээл ордог 102 багшийг бид сургалтад хамруулан парламентын боловсролын сургагч багшийн хөтөлбөрийг ажиллуулсан. Энэ хүрээндээ парламентын ордныг нээлттэй ордон болгох хөтөлбөр аян зохион байгуулж, үүнд 1600 багш, сурагчид оролцсон байна. Парламентын боловсрол хөтөлбөрийг хэрэгжүүлж байгаатай холбогдуулаад иргэд, зочдыг Төрийн ордонд танилцуулах журамд өөрчлөлт оруулахаар бид төлөвлөн ажиллаж байна. Ингэснээр ерөнхий боловсролын сургууль мөн ахлах сурагчид тус хөтөлбөрт хамрагдах, Төрийн ордонтой танилцах арга хэмжээнд хамрагдах боломжтой болох үйл ажиллагаануудыг бид хийж байна.

Өсвөрийн парламент хөтөлбөрийн хувьд 2021 онд Уур амьсгалын өөрчлөлт, хог хаягдлаар, 2022 онд Эрчим хүчний хэмнэл, байгаль орчинд ээлтэй хэрэглээ гэсэн сэдвүүдээр явуулж 9-11 дүгээр ангийн 181 сурагчийг хамруулсан байна. Үүнээс гадна бид хууль сурталчлах төвийг байгуулсан байгаа. Хууль сурталчлах төвийг иргэд олон нийтийн оролцоог хангах зорилгоор Швейцарын хөгжлийн

2023 ОНЫ 07 ДУГААР САРЫН 05-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

агентлагтай хамтран байгуулсан байгаа. Эхний аймгууд Баянхонгор, Өвөрхангай аймгуудад ажиллаж байна. Мөн энэ он, ирэх жил бол уг хууль сурталчлах төвийг бусад аймгуудад байгуулахаар үйл ажиллагаагаа төлөвлөн ажиллаж байгаа.

ХМОНХХ-ээс тайлант хугацаанд 2600 контентыг бэлдсэн байгаа. Мөн парламентын подкастыг шинээр бэлтгэн үйл аж ажиллагаагаа явуулж мөн хүмүүст иргэдэд ингээж нэвтрүүлсэн байгаа.

Төрийн мэдээлэл сэтгүүлийн хувьд нэг онцлог байгаа. Энэ тайлант хугацаанд Төрийн мэдээлэл сэтгүүлийг хос хэлээр явуулах ийм хууль тогтоомжтой байгаа. Энэ хүрээндээ бид нар 21, 22 онд Төрийн мэдээллийг уйгаржин бичгээр явуулж байгаа.

Түүнээс гадна Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой иргэд, зочдыг танилцуулах 1732 арга хэмжээг зохион байгуулсан байна. 33314 иргэн оролцсон байгаа. Мөн энэ хүрээндээ 27 видео контентыг бид бэлдэж, иргэд олон нийтэд түгээсэн байна. Уг үйл ажиллагааг парламентын ордонтой танилцаж байгаа иргэд маань нэлээд ойлгомжтой бөгөөд бас хүртээмжтэй ийм нэвтрүүлэг болсон байна гэдэг энэ саналыг, хүсэлтийг мөн сайжруулах талаар бас бидэнд ингээж хэлсэн байгаа.

Парламент түүний Тамгын газрын үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдал сайжирч, мэдээ мэдээллийг олон нийтэд түгээх үйл ажиллагааны цар хүрээ, хүртээмж нэмэгдэж, олон нийтийн харилцах харилцааны шинэ соёл бүрдэж эхэлсэн нь тайлант хугацааны онцлог ийм үйл явц боллоо.

Мөн бид нар бэлтгэн түгээсэн нэвтрүүлгүүдийн хувьд 748 текст мэдээлэл, 45210 гэрэл зургийг авч баримтжуулсан байгаа. 89 хэвлэлийн бага хурлыг зарласан. Мөн 47 удаагийн шууд

дамжуулалтыг энэ тайлант хугацаанд хийсэн байна. Ингээж ажилласнаар Улсын Их Хурал Байнгын, дэд, түр хороо, Тамгын газрын үйл ажиллагаатай холбоотой хэвлэлийн бага хурал зохион байгуулж, тухай бүр хэвлэл мэдээллийн ажлын хэсгийн гишүүд холбогдох бусад хүмүүсийг ХМХ-д ярилцлага өгүүлэх, ингэснээрээ бас парламентын нээлттэй ил тод байдлыг хангахад чиглэн ажилласан.

5 дугаарт, Парламентын судалгаа сургалтын чиглэлээр та бүгдэд хийсэн ажлаа хураангуйлан танилцуулъя.

131 судалгааг Улсын Их Хурлын гишүүдэд ингээж бид гаргаж өгсөн байна. Үүнээс 81 судалгаа мөн 5 дүн шинжилгээ, 31 мэдээлэл гэсэн нэг мэдээллийн контент, 113 тойм судалгаануудыг гаргасан байгаа.

94 сургалт, судалгааг явуулсан байгаа. Үүнд 4300 давхардсан тоогоор оролцсон байгаа. Үүнээс 95,5 хувь нь танхимаар, 4,5 хувь нь бич цахимаар оролцсон байгаа юм. Түүнээс гадна энэ тайлант хугацаанд хийсэн нэг чухал ажил бол парламентын цогц сургалтын хөтөлбөрийг боловсруулсан асуудал байгаа. Энэ цогц сургалтын хөтөлбөрийн хүрээнд 13 дэд хөтөлбөрийг боловсруулсан байгаа юм. Энэ хүрээндээ сая бас бид нарын хийсэн нэг гол ажил бол хууль тогтоомжийн төслийг боловсруулахад оролцдог хуулийн төсөл боловсруулагчдад зориулсан сургалтыг бид бас амжилттай зохион байгуулсан байгаа юм.

Хууль тогтоох үйл ажиллагааг шинжлэх ухааны судалгаа, шинжилгээ мөн баталгаа нотолгоонд суурилан энэхүү хүрээндээ дэлхийн улс орнуудын парламентын судалгааны албадын сайн туршилага, шилдэг жишигт нийцүүлэн төлөвшүүлэх чиглэлд ахиц гарсан байгаа. Мөн бүтэц зохион байгуулалт, үйл ажиллагаа жигдэрч, хүртээмж

2023 ОНЫ 07 ДУГААР САРЫН 05-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

нэмэгдсэн нь өнгөрсөн 2 жилийн хугацаан дахь гол үр дүн гэж дүгнэж байна.

6-д, Улсын Их Хурлын гадаад харилцаа, хамтын ажиллагааны хөгжүүлэх чиглэлээр

23 хамтын ажиллагаа гадаад харилцааны хувьд энэ тайлант хугацаа нэлээд өвөрмөц хугацаа байсан. Яагаад вэ гэвэл Ковид 19-ийн хязгаарлалттай ийм цаг хугацаа байсан. Мэдээж одоо бол ковидын 19-ийн хязгаарлалт цуцлагдсантай холбоотойгоор бид нар гадаад харилцаа, хамтын ажиллагаагаа өргөжүүлэх, үр нөлөөг дээшлүүлэхээр тодорхой түвшинд ажлуудыг төлөвлөн явуулж байгаа. Энэ хугацаанд илүүтэй бид нар биечлэн хурал, зөвлөгөөн, хамтын ажиллагаанд оролцохоос илүү цахимаар үйл ажиллагаануудыг зохион байгуулсан байгаа. Ингээд 47 гадаад арга хэмжээг зохион байгуулсан.

Түүнээс гадна Улсын Их Хурал Олон улсын парламентын хооронд Хүний эрх, жендерийн мэдрэмжтэй парламентыг бий болгох чиглэлээр санамж бичгийг байгуулсан байгаа. Энэ хүрээндээ бид бас тодорхой үйл ажиллагаануудыг төлөвлөн ажиллаж байна.

Улсын Их Хурлын Тамгын газрын гадаад харилцааны хувьд бид нар 2023 онд нэлээд зорилтуудыг дэвшүүлэн төлөвлөн ажиллаж байгаа. Цар тахлын үе цуцлагдсантай холбоотойгоор бид илүүтэй Улсын Их Хурлын гишүүд болоод Улсын Их Хурлын Тамгын газрын ажилтнуудыг гадаадад сургах, тодорхой хугацаа нь богино, дунд, мөн мэргэжлийг нь дээшлүүлэх чиглэлээр тайлант хугацаанд өндөр түвшинд ажилласан гэдгээ та бүгдэд илэрхийлье.

7. Тамгын газрын захиргаа санхүүгийн удирдлагын чиглэлээр хийсэн ажлыг товчлон танилцуулъя.

Энэ тайлант хугацаанд Тамгын газрын зохион байгуулалтын бүтэц, орон тоо, мөн чиг үүрэгт өөрчлөлт оруулж, үйл ажиллагааг нарийвчлан зохицуулсан 42 дүрэм журмыг шинэчлэн мөрдөж байна. Энэ хүрээндээ 133 албан тушаал, албан тушаалын тодорхойлолтыг шинэчлэн баталсан байгаа. Энэ маань Төрийн албаны хууль тогтоомжид бас нийцүүлэн уг ажлуудыг хийсэн байгаа.

771 өргөдөл, гомдлыг бас шийдвэрлэж ажилласан. Энэ хугацаанд Төрийн хэмнэлтийн хууль бас үйлчилж байсан учраас бид бас Төрийн хэмнэлтийн хуулийг дагаж мөрдөж ажилласан. Захиргаа санхүүгийн үйл ажиллагааны хувьд эрсдэлийн удирдлагын бодлогод баталж энэ хүрээндээ бид үйл ажиллагаагаа явуулсан байгаа юм.

Ингээд дүгнэж хэлэхэд парламентын мэргэишсэн, хариуцлагатай, бүтээлч албыг төлөвшүүлэхэд чиглэсэн эрх зүйн шинэ орчин, оновчтой бүтэц зохион байгуулалт бүрдэж, ажиллагсдын мэргэшил, ур чадвар, ёс зүй дээшилж, ажиллах нөхцөл нийгмийн баталгаа сайжирснаар Тамгын газар шинэ дэг, мөн соёл хэвшиж буйг өнгөрсөн 2 жилийн чухал ололт мөн гэж бид дүгнэж байна.

Та бүгдэд 2023 оны зорилтыг тарааж өгсөн байгаа. Уг 2023 оны зорилтод 2020-2024 оны стратеги төлөвлөгөөний 7 чиглэлээр 21 зорилт, 229 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байгаа.

Ингээд Улсын Их Хурлын Тамгын газар 2023 онд хэрэгжүүлэхээр дэвшүүлсэн зорилт, тулгамдсан асуудлуудаа иуурхай, хариуцлагатай, чанартай, үр дүнтэй шийдвэрлэж, Монгол Улсын Их Хурал парламентад ёс, парламентын ажил шинэчлэлийг бэхжүүлэх үндэс суурийг бүрдүүлж чадна гэдэгтээ итгэлтэй байна. Та бүхэнд анхаарал тавьсан явдалд баярлалаа.

2023 ОНЫ 07 ДУГААР САРЫН 05-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

Н.Энхболд: Өлзийсайхан даргад баярлалаа.

Тамгын газрын 21, 22 оны үйл ажиллагааны тайлантай холбогдуулаад асуух гишүүд байвал нэрээ өгье. Пүрэвдорж гишүүнээр тасаллаа. Адьшаа гишүүн.

Ш.Адьшаа: Тамгын газрынхаа тайланг өнөөдөр бид сонсож байна. Энэ парламент байгуулагдаад эхний 2 жил бас цар тахлын улмаас бид олон сорилтуудыг хамтдаа давж туулсан. Энэ парламентын Тамгын газар цахим парламентыг бэхжүүлэх, парламент ёсыг бэхжүүлэх талаар бас Тамгын газрын дарга Өлзийсайхан болон бусад хүмүүс бас итгэл зүтгэлтэй ажилласан гэдгийг би энд тэмдэглэж хэлэхийг хүсэж байна.

Парламентын Тамгын газар гэдэг бол олонх, цөөнхийн төлөөллийг түүнд хандах хандлага бол хууль тогтоомжийн хүрээнд тэгш байх ёстой гэсэн ийм ойлголттой байгаа. Сүүлийн үед энэ хэмнэлтийн тухай хууль, шүүр ажиллагаа гэдэг энэ Засгийн газраас хэрэгжиж байгаа энэ асуудал энэ Улсын Их Хурлын Тамгын газрын сүүлийн үед энд томилогдсон хүмүүс дээр би ихээхэн эргэлзээтэй ийм байна. Парламентын энэ засаглалын гол мөн чанар нь цөөнхийнхөө гаргасан санал, хүсэлтийг бас дэмжиж, Улсын Их Хурлын удирдлагатай зарчмын хувьд тохиролцсон асуудлуудыг оруулж ирж энэ хэлэлцүүлэх ийм үндсэн зарчимтай, ингэж явж ирсэн ийм бодлоготой.

Бид аливаа асуудлыг зөвшилцлийн түвшинд аливаа асуудлыг бид хэлэлцээний түвшинд ингээд шийдээд олон асуудлууд ард нь гарсан. Үндсэн хуулиас эхлүүлээд. Улсын Их Хурлын дарга дээр аливаа асуудлыг цөөнхөөс оруулах гэж удирдлагаас өгсөн чиглэл доод шатдаа ирээд завхардаг, тэр хүмүүсээс бид гуйлга гуйдаг ийм байдалд байна. Үүнийг би хариуцлагатайгаар дараа нь үүнийг би

олон нийтэд ч гэсэн мэдэгдье гэж бодож байгаа.

Цөөнхөд үйлчилдэг нэг шалгуур, олонхонд үйлчилдэг нэг шалгуур байна. Эндээ энэ Улсын Их Хурлын Тамгын газар, удирдлагууд дүгнэлт хийгээсэй гэж бодож байна. Энэ бол зөвхөн олонхонд үйлчилдэг ийм Тамгын газар биш ээ. Энэ бол төрийн байгууллагын бүтцийн асуудал, байгууллага. Энэ бол Монгол Улсын хуулийн дагуу явагдах ёстой. Одоо бид нар нэг аливаа асуудал хэлэлцэхийн тулд энэ их олон дэд дарга нарыг чинь хадаг барьж гуйдаг ийм л байдалд бид хүрч байна шүү дээ. Дарга нь нэг юм ярьдаг, Ерөнхий нарийн бичгийн дарга дээр нь орохоор нэг юм ярьдаг, ийм байдлаар цаашидаа явах юм уу. Би зүгээр үг хэлж байгаа шүү, асуулт байхгүй, би үүнийг дараа нь хариуцлагатай ярина.

Бид бас өнөөдөр ард түмний төлөөлөл, хууль болон бусад зүйлийг санаачлах эрхтэй, үүнийг ээ л хий хийж байгаа юм. Түүнээс биш бид энд нэг социализмын үеийн нэгдлийн хонь цохиулдаг даргыг гуйж бид амьдрахгүй, ингэж ажиллахгүй гэдгийг энд хэлье. Надад асуулт байхгүй.

Н.Энхболд: Баярлалаа. Батсуурь гишүүн.

Ж.Батсуурь: 92 онд ардчилсан Үндсэн хууль байгуулагдсанаас хойш 8 удаагийн сонгууль болсон. Тэр үед түүнээс авхуулж парламентын засаглалыг хөгжүүлэх Улсын Их Хурал түүний Тамгын газар үйл ажиллагаагаа явуулж ирсэн. Мэдээж анх байгуулагдаж байх бодох юм бол орон тооны хувьд, бааз суурийн хувьд, нөхцөл байдлын хувьд, гадаад дотоод харилцааны хувьд, мэргэжил ахуйн хувьд үнэхээр харьцуулиггүй хөгжиж дэвшсээр ирсэн. Мэдээж энэ Тамгын газартаа амьдрал ахуйгаа олоод бас 3 жил болж байна. Энэ бас үе үеийн ажиллаж байсан хүмүүсийн туршилага дээрээ тулгуурласан, манай дунд үеийнхэн, залуу үеийнхэн маань бас

2023 ОНЫ 07 ДУГААР САРЫН 05-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

хичээж зүтгэж ажиллаж байгаа гэдгийг бас тэмдэглэн хэлэх нь зөв байх аа гэж ингэж бодож байна.

Би асуулт асуух гэж байснаа асуулт үг хоёроо нийлүүлье гэж ингэж бодож байна. Тайланг бүгдийг маш нямбай бүгдийг сонслоо. Мэдээж санал нийлэх зүйлүүд байна, санал нийлэхгүй ч байх зүйлүүд байна. Гэхдээ том утгаараа парламентын засаглалыг хөгжүүлэх энэ чиглэл рүү бас нэлээд чамбай явж байгаа бас болж байгаа, бүтэж байгаа гэсэн ийм санааг илэрхийлэх гэсэн юм.

Одоо 9 дэх удаагийн сонгууль болно. Сая Үндсэн хуулиар 126 гишүүнтэй болно. Байр суудлын асуудлаас авхуулаад, түүний хангамжийн асуудлаас авхуулаад, үйлчилгээний асуудлаас авхуулаад маш их зүйл та бүхний өмнө тулгамдаж байгаа байх. Тэр нь ч өөрөө энэ 23 оны зорилт дээр бодвол суусан байх гэж ингэж бодож байна. Асуултаа би хариултын хувьд авахад жишээлэх юм бол өнгөрсөн 3 жилийн хугацаанд мэдээж гадаад, дотоод томилолт, мэргэжил арга зүйн сургалтууд гээд давхардсан тоогоор асуувал нэлээн том тоо гарах байх. Гэхдээ энд нь ямарт нь хамрагдаад байдаг юм, ямарт нь хамрагддаггүй юм. Жишээ нь миний бие 3 жил Улсын Их Хуралд суухад 1 ч удаа гадаад томилолтод явж үзээгүй. Тэгэхээр давхардсан тоогоор гадаадад томилолтод явсан, сургалтад явсан гишүүдийн тоог сонсох юм нэлээд том тоо гарна. Ер нь парламентын засаглал гэдэг бол харилцан зөвшилцлийн нийгмийн бүх хүсэл эрмэлзлийг хангасан тэр байр суурийг л хангаж ажиллаж байх ёстой ийм Тамгын газар. Ялангуяа сая Адьшаа гишүүн ч хэлж байна. Ер нь эрх баригчдын үйл ажиллагааг зохицуулдаг Тамгын газар бол огт биш. Ялангуяа өнөөдрийн эрх баригчид бол Монголын нийт ард түмний, нийт сонгогчдын нэг 40 гаруй хувийн саналаар Монголын төр 100 хувь бүрдчихээд байгаа юм. Тийм учраас Монголын төр гэдэг бол Монголын ард түмэн. Монголын ард түмэнд үйлчлэх

ёстой энэ хуулийг үйлдвэрлэдэг газрын ажлыг хийж байгаа хүмүүс гэж л ойлгох ёстой. Цаашид ч гэсэн.

Тийм учраас цөөнхийн байр суурийг эрх баригчдын байришлаас бараг тэнцүү бөгөөд илүү давж үзэж байх ёстой. Яагаад вэ гэхээр өнөөдөр Монголын ард түмний нийт сонгогчийн 60 гаруй хувь нь өнөөдөр эрх баригчдыг сонгоогүй, 60 орчим хувь нь. Тийм болохоор тэнд байгаа ард түмний хүсэл эрмэлзэл өнөөдөр өргөн барьсан хуулийн үзэл баримтлалд орж уу, үгүй юү. Мөн техник үйл ажиллагаа бусад зүйлүүд нь болж уу, үгүй юү. Парламентын хэлэлцүүлгүүд, сургалтууд, орон нутгийн бөгөөд гадаад томилолтууд энэ бүх байдал үйл ажиллагааг жин банг нь тэнцүүлж явах энэ үүрэг бол өөрөө парламентын Улсын Их Хурлын Тамгын газрын үүрэг л гэж ингэж харж байх ёстой.

Тэгээд мэдээж энэ олсон үр дүнгээ улам арвижуулж ирэх сонгуулиар бүрдэх 126 гишүүнтэй тэр томоохон парламентын анхны үйл ажиллагааг бэлтгэх энэ их ажилд нь амжилт хүсье. Тэгээд өмнөх алдаануудаа засаж илүү их амжилт ... /минут дуусав/

Н.Энхболд: Баярлалаа. Пүрэвдорж гишүүн. 2 гишүүн үг хэлчихлээ. Тийм ээ.

Б.Пүрэвдорж: Тэгээд би ч одоо нэг их тийм Тамгын газрын үйл ажиллагаанд нэг их ордог ч үгүй, нэг тэр хавиар явдаг ч үгүй, зөвхөн өөрийнхөө л урдах нөгөө нэг сөрөг хүчнийхээ ажлыг хийдэг. Хааяа нэг бас нэг яг энэ хуультай холбоотой зөвлөгөөнүүд авахад манай Тамгын газрын албан хаагчид үнэхээр мэргэшсэн сайн байдаг. Яг таг өгдөг. Ер нь энэ албан хаагчдын олон жил бас ингээд энэ хууль дээр нухлуулаад, цаасан дээр суугаад ингээд явсан тэр албан хаагч нар маань бас энэ Тамгын газрын үйл ажиллагааг бас нэлээн сайн түвшинд хүргэж байгаа гэдгийг хэлье.

2023 ОНЫ 07 ДУГААР САРЫН 05-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

Тэгээд бидний бас нэг сайн хийсэн зүйл бол энэ компаниуд болон яамнууд сайн бэлтгэгдсэн энд байгаа хүмүүсийн маань цалингаар болон бусад зүйлээр аваад явчихдаг байсныг нь бас тодорхой цалинг нь нэмэгдүүлсний үр дүнд энд тогтвор суурьшилтай ажиллах ийм боломжийг бий болгосон байгаа. Түүний үр дүнд бас ингээд сайн хуулиуд гарах тэр боломжийг янз янзын алдаа, дутагдалгүй, асуудалгүй хууль гарах тэр боломжийг л гаргаж өгч байгаа л гэж би харж байгаа.

Тэгэхээр мэдээж юу байдаг юм цагийн эргэлтэд энэ төр засаг солигдож, холигдож л явдаг. Тэр үедээ л энэ үйл ажиллагаатай бол мэдээж эрх баригч нарт илүү үйлчилж л таараа. Тэр бол тодорхой асуудал байхгүй юу даа. Тэгэхдээ ер нь бас тодорхой хэмжээгээр энэ цөөнхийнхөө эрх ашгийг бас хангаад явах тал дээр яг миний орж тавьсан хүсэлтээр аль болох л юу яадаг юм, би нэг их тийм хөрөнгө мөнгөний асуудал ерөөсөө ярьдаггүй. Өөрөөр хэлбэл хууль тогтоомжийн тухай тэд нартай холбоотой мэдээллийг авах тал дээр маш шуурхай ажилладаг. Тийм учраас Тамгын газрын энэ 21, 22 оны тайлан дээр би сэтгэл хангалуун байна. Тэгээд улам сайн ажиллаарай гэж хэлье. Баярлалаа.

Н.Энхболд: Гишүүд бүгдээрээ уг нь асуултын цаг дээр үг хэлчихлээ. Дэгээр үг хэлж болно. Бас үг хэлэх гишүүн байна уу. Оюунчимэг гишүүн, Тогтохсүрэн гишүүн. Оюунчимэг гишүүн.

М.Оюунчимэг: Улсын Их Хурлын Тамгын газрын 20, 21 оны үйл ажиллагааны тайланг хэлэлцэж байна. Энэ 20, 21 он бол бас амаргүй он жил байсан. Ялангуяа манай улсын хувьд яг дэлхийн бусад улс орон манай нэгэн адил ковидын нөхцөл байдал, бидний хүсээж хүлээгээгүй тийм цагийн нөхцөл байдалд ороход бас парламент энэ хууль тогтоох дээд байгууллагын үйл ажиллагааг зогсоолгүй дээрээс нь бас эрүүл ахуйн шаардлагыг хангаад энэ үйл ажиллагааг тогтвортой явуулах тал дээр манай Их

Хурлын Тамгын газар маш сайн ажилласан. Тэр үед. Би бас тэрийг нэг тэмдэглэж хэлье гэж бодож байна.

2-т нь, өөрчлөлт их гарч байгаа. Манай Өлзийсайхан даргатай Тамгын газрынхны хувьд юун дээр илүү ингээд гарч байна гэхээр Улсын Их Хурлын гишүүдэд өгч байгаа энэ бичиг материалыг анализ үнэлэлт дүгнэлт хийх тэр Засгийн газраас орж ирж байгаа болон бусад газраас орж ирж байгаа хуулийн төслүүд болон түүн дээр бас яг энэ аудитын дүгнэлттэй адилхан Хяналт үнэлгээний хэлтэс маань маш сайн тийм анализ бодлогын чин шинж чанартай дүгнэлтүүд хийгээд энэ нь Улсын Их Хурлын гишүүдэд ялангуяа бас шинэ гишүүдэд ч гэсэн маш сайн тийм мэдээлэл болж өгдөг. Түүн дээр би бүр албаар хэлье гэж бодож байгаа. Үүнийгээ бид цаашид улам боловсронгуй болгох ёстой юм байна лээ. Бид Европын орон, АНУ, Японы парламентад очиход яг энэ нэг бодлогын шинж чанартай аливаа орж ирж байгаа парламентад яам, Тамгын газар, бусад газраас өгч байгаа тэр баримт бичиг дээр дүн шинжилгээ анализ хийгээд энэ нь бол Улсын Их Хурлын гишүүдийн гарын авлага болох талд нь өөрөө бүх талаасаа их чухал ач холбогдолтой. Үүнийг харин сүүлийн энэ жилүүдэд манай Их Хурлын Тамгын газрын хэлтсүүд маань маш сайн хийж байгаа. Би үүнд талархал илэрхийлье. Цаашидаа үүнийг илүү сайн болгох хэрэгтэй гэж бодож байгаа.

Одоо бас энэ тамгын газрын ажилтнуудаа нөгөө гадаад дотогш нь сургах, 2 улс хоорондын парламент дээр Тамгын газрын ажилтнуудыг мэргэшүүлэх зэрэг ажлууд дээр бид бас Их Хурлын маань өөрөө илүү их анхаарч ажиллах нь зөв юм байна лээ. Жишээ нь ХБНГУ бол яг Их Хурлын Тамгын газрын ажилтнуудыг солилцох маягаар сургах, хамтран ажиллах чиглэлээр бид энэ зунаас үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд бэлэн байна гэдгийг сая парламентын гишүүд бид нарыг айлчлахад бас хэлсэн

2023 ОНЫ 07 ДУГААР САРЫН 05-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

байгаа. Тэгээд энэ дээр би бас тэмдэглэж хэлье гэж бодож байна.

Нөгөө талаасаа бас гадаад улс орнуудын туршилага дээр үндэслэсэн хэлэлцүүлгүүдийг манай Их Хурлын Тамгын газар сүүлийн үед хэвшил болгож маш сайн хийж байгаа. Манай Цогзолмаа дарга энэ бусад гадаад харилцааны хэлтэс энэ тэр маань шууд онлайн ар холбогдоод зарим нь өөрөө энд оролцоод, нийгэм олон нийтийн анхаарлын төвд байгаа сэдвээр хэлэлцүүлгүүдийг хийж тэнд бас олон нийтийг ард иргэдийн төлөөллийг, төрийн бус байгууллагууд, иргэний нийгмийн төлөөллүүдийг оролцуулах, парламент бол ард түмний төлөөллийн байгууллага гэдэг утгыг нь харуулах парламентын ардчиллыг бэхжүүлэх энэ тэр дээр бас санаачилгатай ажиллаж байгаа. Энэ бүх зүйл нь бас 20, 21 оны үйл ажиллагааны тайланд нь дурдсан байна. Тэгээд энэ бүх зүйлээ улам боловсронгуй болгох дээр цаашидаа анхаараарай гэдгийг хэлье гэж бодож байна. Үнэхээр сайн ажиллаж байгаа шүү бас.

Н.Энхболд: Баярлалаа.
Тогтохсүрэн дарга.

Д.Тогтохсүрэн: Тамгын газрын 22 оны тайлан хэлэлцэж байна. Ерөнхийд нь манай Тамгын газар бол сүүлийн үед их мэргэшиж, сайн ажиллаж байгаа гэдгийг бас онцолж тэмдэглэе гэж бодож байна. Ялангуяа энэ 2023 оны энэ хаврын чуулган аягүй их ачаалал ихтэй, бас их урт хугацаанд үргэлжилсэн ийм чуулган байлаа. Энэ Үндсэн хуулийн өөрчлөлт, Сонгуулийн хууль, Улс төрийн намын хууль энэ Боловсролын багц хууль, Нийгмийн даатгалын багц хууль гээд их олон асуудлууд тэр дотроо төсвийн тодотгол хүртэл орлоо. Энэ их ачаалалтай үед манай Тамгын газар бас сайн ажилласан гэдгийг бас онцолъё.

Цаашид нэг 2 зүйл дээр би анхаараарай гэж санал хэлэх гэж байгаа юм.

1 дүгээрт нь, энэ 126 гишүүнтэй болж байгаа. Одоо ингээд дараагийн парламент. Түүний бэлтгэлийг бид нар хангах ёстой. Тэгэхээр энэ бэлтгэл зохион байгуулалтын ажлыг манай Тамгын газарынхан маш их сайн хийх хэрэгтэй байна. Энэ Үндсэн хуулийн өөрчлөлтийг биежүүлж цаашидаа бусад хуулиар хэрэгжүүлэх асуудал байгаа. Энэ хүрээнд энэ Их Хурлын хууль, Их Хурлын хуралдааны тухай хууль эд нар чуулганы хуралдааны хууль эд нарт шинэчлэн найруулагдана. Эдгээрийг боловсруулах чиглэлд бол би их онцгой анхаарах ёстой байх гэж бодож байна.

2 дугаарт нь, гадаад харилцаатай холбоотой асуудал байгаа юм. Энэ сүүлийн үед Их Хурлын гишүүд ингээд гаднын яамны зардлаар маш их гадаадад яваад байгаа юм. Энэ дээр нэг Жамбалсүрэн дарга нэг үнэлгээ хийж хэдүүлээ нэг ярьж баймаар байгаа юм. Тийм. Тэгэхгүй л бол энэ гадаад харилцаа ингээд л жаахан замбараагүй явах гээд байгаа. Гэхдээ бид нар аль болохоор хорьж л байгаа ч гэсэн яамны санхүүжилтээр, төслийн санхүүжилтээр гэдэг нэрийн доор бас яваад байна. Тийм учраас энэ гадаад харилцааны юман дээр нэг анхаарч өгөх ёстой юм шиг байгаа юм. Ийм зүйлийг хэлье. Тэгээд амжилт хүсье. Шинэ бодлого хэрэгжүүлэх, тавьж байгаа зорилтыг хэрэгжүүлэх чиглэлд бол сайн ажиллаж байгаа.

Н.Энхболд: Гишүүд үг хэлж дууслаа.

Бид нар өнөөдөр Байнгын хороогоор Улсын Их Хурлын Тамгын газрын 21, 22 оны үйл ажиллагааны тайланг хэлэлцэж байна. Үг хэлсэн гишүүд ерөнхийдөө Тамгын газрын үйл ажиллагааны талаар бас хангалттай сайн ажиллаж байгаа гэдгийг хэлж байна. Би үүнтэй бас ер нь санал нэг байна.

Бид сая энэ 2 жилийн хугацаанд бас миний харж байгаагаар 2 зүйл дээр

2023 ОНЫ 07 ДУГААР САРЫН 05-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

нэлээн том урагш нь 3 ч зүйл дээр дэвшил гаргасан ийм үйл ажиллагаа явуулсан гэж Тамгын газрыг үзэж байгаа.

1 дүгээрт, энэ ковидтой холбоотойгоор бид нар Улсын Их Хурлын үйл ажиллагааг орчин үеийн шаардлагад нийцүүлээд, хэрэгцээтэй үед цахимаар явуулж болдог юм байна гэдгийг ямар нэгэн том хэл амгүйгээр сайн зохион байгуулсан. Энэ бол өөрөө 1 дүгээрт Тамгын газрын ажлын их том үзүүлэлт. Нөгөө талаар ерөөсөө Монгол Улсын Их Хурал төрийн эрх барих дээд байгууллага энэ үйл ажиллагаагаа орчин үеийн шаардлагад нийцүүлээд явуулж чадаж байгаа юм байна гэдгийг харуулсан ийм амжилт гэж ингэж бодож байгаа.

2 дугаарт, судалгаа шинжилгээний ажлын талаар бас сая гишүүд хэллээ. Ялангуяа сүүлд одоо бид нар сая нөгөө Хууль зүйн хүрээлэнг дэргэдээ авчихсан байж байгаа. Хүчин чадал маань сайжирч байгаа. Сая сүүлийн 2 жилийн хугацаанд ч гэсэн би бол бусад гишүүдтэй бас санал нэг байна. Ялангуяа гишүүдийг мэдээллээр хангах, судалгаагаар хангах энэ тал дээр ер нь урьд өмнөхтэй харьцуулахад томоохон ахиц гарсан гэж ингэж харж байгаа. Үүнийгээ цааш нь улам сайжруулах хэрэгтэй. Тэр тусмаа хүчин чадал маань бэхэжчихсэн байна. Тийм ээ, ажилчдын маань нийгмийн халамж, цалин хөлсний асуудал бас сайжирсан. Үүнтэй холбогдуулаад та нарт тавих шаардлагууд нэмэгдэнэ. Ингээд нэмэгдэж байгаа хүчин чадлаа өөрсдийнхөө бололцоотой ашиглаад энэ чиглэлийнхээ ажлуудыг цааш нь улам чанаржуулж ажиллах хэрэгтэй гэдгийг хэлэх хэрэгтэй байна.

Дотоод зохион байгуулалтын хувьд бол жишээ нь Байнгын хороодын ажлын алба, Зөвлөхүүдийн алба 2-ын хоорондын уялдаа холбоог бас түргэн шуурхай тухайн хэлэлцэж байгаа асуудлуудтай уялдуулаад ойрхон, ойрхон зохицуулж байх ийм шаардлагууд бас

заримдаа харагддаг. Заавал жишээ нь Төрийн байгуулалтын байнгын хороо дээр энэ хүн л ажиллах ёстой гэдэг маягаар биш шаардлагатай том хуулиуд хэлэлцэж байгаа үеэр Зөвлөхүүдийн албанаасаа хүчийг нь нэмээд тийм ээ, ажлынх нь уялдаа холбоог сайжруулаад ажиллах ийм шаардлагууд бас байгаа шүү гэдгийг хэлэх хэрэгтэй байна.

2 жилийн хугацаанд бас нэг бид нарын ажилд та нарын ажилд шинээр гарсан нэг зүйл энэ хяналт. Үндсэн хуулиар Улсын Их Хурлын хяналтын функцийг нэлээн том хэмжээнд аваачиж өгсөн. Үүний эхлэлийг их сайн тавьсан гэж бодож байгаа. Зохион байгуулалтын асуудал дээр. Энэ дээр манай Тамгын газрын оролцоо, та бүхний хүчин чадал бас их хэрэг болсон. Цаашидаа энэ ажил Улсын Их Хурлын үйл ажиллагааны их томоохон хэсэг болж явах ёстой. Энэ дээр цааш цаашидаа түрүүчийн хийж байсан ажлуудаасаа бас сургамж аваад улам илүү сайн болох ийм шаардлагууд байгаа гэдгийг хэлэх хэрэгтэй байна.

Сая бас олон гишүүд хэлчихлээ, олон давтаад яах вэ. Их Хурлын гишүүдийн тоо нэмэгдсэн. Үүнтэй уялдаад дотоод зохион байгуулалтын асуудал, ялангуяа өрөө тасалгаа хуваарилахаас эхлээд тэгээд гишүүдтэй ажиллах тал дээрээ маш сайн зохион байгуулалттай ажиллах ийм шаардлага гарна. Энэ дээрээ их анхаарч ажиллах хэрэгтэй байна гэдгийг хэлье.

Тэгээд эцэст нь хэлэхэд ер нь Тамгын газрын саяын миний хэлсэн гишүүдийн ярьж байгаа энэ зохион байгуулалттай холбоотой гишүүдэд туслахдаа холбоотой ажлууд их чухал. Энэ мэдээж онцгой. Тэгэхдээ би бол жишээ нь Тамгын газрын ажлын хамгийн гол үүргийн нэг бол эндээс гарч байгаа аливаа хууль, тогтоол, шийдвэрүүд Үндсэн хууль, бусад хуультай нийцэж байна уу, үгүй юү гэдэг тал дээр дүгнэлт өгөх, үндэслэлийг нь гаргах дээр хамгийн чухал үүрэг гүйцэтгэх газар бол Тамгын

2023 ОНЫ 07 ДУГААР САРЫН 05-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

газар байж байгаа. Бид нар өөрснөө мэднэ, тийм ээ. Аливаа чухал маргаантай асуудал гараад ирэхэд чуулганы хуралдаан дээр үүнийг эрх зүйн талаас нь хуулийн зохицуулалт талаас нь юу гэж үзэж байгаа вэ, аль нь зөв гэж үзэж байгаа вэ гэж Тамгын газраас асуудаг. Үндсэндээ энэ дээр Тамгын газраас хэлж байгаа мэргэжилтнүүдийн зүгээс хэлж байгаа үг бол эцсийн үндэслэл болж явдаг. Цаашаа тэр хууль хууль зөрчсөн гэж үзэгдээд цэц дээр очих нь уу, үгүй юу, олон нийтийн зүгээс хууль зөрчсөн гэсэн шүүмжлэлд өртөх нь үү, үгүй юу гэдэг дээр цэг тавигддаг газар нь үндсэндээ Тамгын газар шүү. Энэ талаас нь бодоод манай ажилтнууд, хэлтэс, албадын дарга нар, ялангуяа хуулийн чиглэлийн улсууд маань маш их хариуцлагатай энэ дээр хандаж байх ёстой шүү гэдгийг албан ёсоор дахиад сануулъя.

Ингээд 21, 22 оны тайланг хэлэлцэж дууслаа.

Би гишүүдээс гарч байгаа, үг хэлсэн гишүүдтэй ерөнхийдөө санал нэг байна. Тамгын газар маань 21, 22 оны ажил нь бол ер нь хангалттай сайн хийсэн, ажил нь чадваржиж байгаа, ажилтнуудын маань чадвар нэмэгдэж байгаа, их залуужсан байгаа манай Тамгын газар. Энэ хүмүүсээ тогтвор суурьшилтай ажиллуулах, мэргэжил дээр нь улам чадваржуулах энэ тал дээр онцгой анхаарч ажиллаарай гэж хэлэх хэрэгтэй байна. Би Тамгын газрын тайланг Байнгын хороогоор хэлэлцсэнийг заавал чуулганаар оролцох шаардлагагүй гэж үзэж байна, Төрийн байгуулалтын байнгын хорооны зүгээс.

2 жилийнх нь ажилд нэг их дүгнэлт өгдөг юм байхгүй л дээ. Тэгэхдээ яах вэ, би гишүүдийнхээ ярьж байгаатай санал уг нь хангалттай сайн ажилласан гэж ингэж дүгнэж байна.

Тэгээд цаашидын ажилд нь амжилт хүсье.

Ингээд Байнгын хороогоор Улсын Их Хурлын Тамгын газрын 21, 22 оны үйл ажиллагааны тайланг хэлэлцлээ.

Өнөөдрийн Байнгын хороогоор хэлэлцэх асуудал гээд дуусаж байна.

Та бүхэндээ амжилт хүсье. Ажлын хэсгийн гишүүд, Тамгын газрынхаа хамт олонд амжилт хүсье. Сайхан баярлацгаараарай.

14.29 цаг

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ
БУУЛГАЖ, ХЯНАСАН:
ШИНЖЭЭЧ

П.ОЮУНГЭРЭЛ